МЭДЭЭ · 2021 оны 3-р сарын 12

ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД 14 ХОНОГИЙН ХУГАЦААТАЙ АЯН ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Говьсүмбэр аймгийн прокурорын газраас аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангитай хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг "Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлье" сэдвийн дор зохион байгуулжээ.

Зөвлөгөөний үеэр аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор Д.Мөнгөнцэцэг прокурорын байгууллагаас эрүүдэн шүүхийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүн болон эрүүдэн шүүх явдлыг гаргуулахгүй байх талаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн дэд дарга, хошууч Н.Энхтүвшин хорих ангийн үйл ажиллагааны талаар тус тус мэдээлэл хийж, ажил хариуцсан алба хаагч нарт үүрэг, чиглэл өгсөн байна.

Мөн прокурорын газраас эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага, зурагт хуудас зэргийг гаргаж, хуулийн байгууллагуудын дунд 14 хоногийн хугацаатай аян зохион байгуулахаар болжээ.





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2810